



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХӨДӨЛМӨР,НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ ИНСТИТУТИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 266613
Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Ахлах аудитор: Г.Жавхлан
Утас: 261885
Цахим хаяг: Gunjidmaag@audit.gov.mn

“И.Эс.Эс.Эс.Аудит” ХХК-ийн
Захирал Ц.Сугармаа
Аудитор: Э.Нарангэрэл
Утас: 99151254
99907511

Компанийн хаяг: “И.Эс.Эс.Эс Аудит” ХХК
Байршил: СБД, 1-р хороо Жамьяан гүний
гудамж-5, Ар Монгол Трэвэлийн байр
Цахим хаяг: esss.audit@gmail.com

2018 оны 2 дугаар сар



1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт



НЭГ. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2018/228/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь тус компанийн аудитуруудын үүрэг юм.


Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 16-ны хооронд хийхээр төлөвлөж, “И Эс Эс Эс Аудит” ХХК-ийн захирал Ц.Сугармаа хянан удирдаж, аудитор Э.Нарангэрэл, туслах аудитор Э.Сайнзаяа нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/, /ТАБ-СТА-А-10/

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2017 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 25-нд буюу хуулийн хугацаанд гаргаж, тус компанид ирүүлсэн болно.

Тус компанийн аудитын баг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 16-ны дотор ҮАГ-ын холбогдох албан тушаалтнуудаар хянуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын удирдлагад гардуулна.

ХОЁР. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын удирдлага нь Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хөдөлмөрийн тухай, Зөрчлийн тухай, Төрийн албаны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.



ГУРАВ. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн үндсэн зорилго нь төрөөс хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалал болон хүн амын хөгжлийн бодлогын суурь судалгаа, шинжилгээ, хэтийн болон ойрын тооцоолол хийж зөвлөмж боловсруулах, чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллага юм.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр зэрэг томоохон бодлогын баримт бичигт холбогдох хууль журам тэдгээрийг шинэчлэхэд шаардлагатай суурь тоон мэдээлэл, зөвлөмжөөр хангах зорилтын хүрээнд 2017 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын чиглэлээр “Барометрийн судалгаа-2017”, “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”, “Цалин хөлсний бүтцийн судалгаа-2017”, “Залуучуудын ажилгүйдэл эдийн засгийн идэвхгүй байдлын судалгаа”, “Ажил олгогчоос ажилтанд тавих шаардлага” зэрэг судалгааг хийж, үр дүнг тайлагнаж ажилласан байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь байгууллагатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалж, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Авлигатай тэмцэх тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, хуулиуд Монгол Улсын засгийн газраас гаргасан тогтоол шийдвэр, дүрэм, журам Сангийн сайд болон салбарын сайд, байгууллагын удирдлагын баталсан тушаал шийдвэр байгууллагын дүрэм, дотоод журам, ёс зүйн дүрэм, журмуудыг мөрдөж ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

ДӨРӨВ. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоож, аудитаар дотоод аудитын талаар менежментийн захидалд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг данс бүрээр түүвэрлэн гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн

үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн “Гүүк софт” ХХК-иас гаргасан Axplorer 3.16 програмыг ашиглаж, санхүүгийн тайланг гаргадаг.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/218 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, даргын 2017 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/13 тоот тушаалаар батлуулж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвгтэй байдлын үнэлгээг хийхэд “Бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзэв. /ТАБ-СТА-В-2/

Материаллаг байдлын түвшинг тооцох суурийг сонгохдоо төсвийн санхүүжилт бага, уламжлалт болон хяналтын эрсдэл бага гэж төлөвлөлтийн шатанд үзсэн тул санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 2.0 хувиар буюу 17,244.4 мянган төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн шатанд энэ нь өөрчлөгдөөгүй болно. /ТАБ-СТА-А-4/

ТАВ. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн дотоод хяналтыг судалж үзэхэд санхүүгийн баримтууд дээр 1болон 2 дугаар гарын үсэг бүрэн зурагдсан, дотоод хяналт зохих хэмжээнд үр нөлөөтэй ажиллаж байна.

ЗУРГАА. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 онд батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг зардлын төрлөөр хуваарилж, байгууллагын дарга, нягтлан бодогч болон төрийн сангийн ажилтнууд төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь 2017 онд төсвийн үйл ажиллагааны зардалд 528,441.0 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 503,244.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 25,196.9 мянган төгрөгөөр зардлыг хэмнэж, Сангийн яамны Төрийн сангийн дансанд төвлөрүүлжээ.

“Хүнс тэжээл, нийгмийн халамжийн “Нэмэлт санхүүжилт” төслөөс 97,482.6 мянган төгрөгийн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нэмэлт санхүүжилтийн данснаас 63,578.0 мянган төгрөг нийт 161,060.6 мянган төгрөгийн санхүүжилт, Хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тендерийн орлогоос 350.0 мянган төгрөг нийт 161,410.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

ДОЛОО. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2017 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээлэл, ажлын гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийн талаар байгууллагын rilsp.gov.mn вэбсайт хуудсанд байршуулсан бөгөөд тайлант жилийн байдлаар мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулж хяналт тавьж ажиллаж байна. 2017 оны 12 дугаар сард Үндэсний аудитын газрын Нийцлийн газраас шилэн дансны хэрэгжилтийн талаар аудит хийсэн ба аудитаар ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй байна.

НАЙМ. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын данс бүрээр эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд орлого, зарлагын дансны зүйл ангиар задалбал нийт 16 нарийвчилсан горим, сорил хийж дүгнэсэн. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол зүйл байхгүй. Аудитын явцад материаллаг зөрчил илрээгүй.

ЕС. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материалын зардал, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, цалин урамшуулал, болон үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгасан. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорилоор байгууллагын нийт санхүүжилтийн болон мөнгөн хөрөнгийн гүйлгээг 70-80 хувь, нийт зардлын 70-80 хувийг түүвэрт хамруулж, горим хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлант жилд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2017 онд нийт 41,735.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч нягтлан бодох бүртгэлд тусгасан. Тухайлбал: 3,049.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 561.0 мянган төгрөгийн програм хангамж нийт 3,610.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, өмнөх жилд бараа материалын дансанд бүртгэсэн 3,300.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөөр шилжүүлэн авсан, “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн “Нэмэлт санхүүжилт” төслөөс 34,055.0 мянган төгрөгийн, ХЭДС-аас 770.0 мянган төгрөгийн нийт 34,825.0 төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч хөрөнгөнд бүртгэсэн байна.

АРАВ. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дараах материаллаг бус алдаа илэрлээ. /ТАБ-СТА-В-4/ Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төв /хуучин нэрээр/ татан буугдан Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 55 дугаар тогтоолоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт болж зохион байгуулагдсантай холбогдуулан 3,653.2 сая төгрөгийн өртөгтэй оффисын байр тус институтийн үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн боловч тус байрны ашиглалтын болон тогтмол зардлын төсвийг 2017 оноос Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын төсөвт баталжээ. Иймд өөрийн эзэмшилд байгаа хөрөнгийн ашиглалтын болон тогтмол зардлын төсвийг хөрөнгө эзэмшиж байгаа газарт нь шилжүүлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын төсөвт зохицуулалт хийх саналыг тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн эзэмшилд байгаа хөрөнгийн төсвийн зардлыг шилжүүлэх талаар арга хэмжээ авч харьяалах дээд байгууллагын шийдвэр гаргуулах

АРВАН НЭГ. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд зөвлөмж өгөх шаардлагагүй зарим материаллаг бус алдаануудыг засч залруулах зөвлөмжийг өгч ажилласан болно.

АРВАН ХОЁР. АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:


Тус институт нь тайлант жилд 8 орон тоо хэмнэж ажилласан бөгөөд дотоод аудиторыг энэхүү орон тооны хязгаарт багтаан авч, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрэм, журмын хүрээнд эрх зүйн актыг боловсруулан ажиллах талаар судалж үзэх хэрэгтэй.

АРВАН ГУРАВ. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгана.

АРВАН ДӨРӨВ. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Тус институтийн эзэмшилд байгаа 3,653.2 сая төгрөгийн өртөг бүхий оффисын байрны зардлын төсвийг шилжүүлэх талаар харьяалах дээд байгууллагад санал оруулж шийдвэрлүүлэх гэсэн 1 зөвлөмж өгөв.



АРВАН ТАВ. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаар 1 зөвлөмж өгч, зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.

АРВАН ЗУРГАА. Зөвлөмж:

Менежментийн захидалд материаллаг бус алдаа, зөрчлийн талаар бичиж, зөвлөмж өгсөн болно.

АРВАН ДОЛОО. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн даргын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

